



ТӨВ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Төв аймгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com
Факс: 70272582

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273465
И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: Ж.Бямбацогт
Утас: 70273463
И-мэйл: j.beegii@gmail.com

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:
Төв аймаг Зуунмод сум 6-р баг
Төрийн байгууллагуудын 2-р ордон
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2017 оны 02 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2017/24/СТА-ЗГТС/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дүгээр сарын 25-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн аудитор Ж.Бямбацогт хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 26-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 26-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 23-нд Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын зорилт, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэхээр заагдсаны дагуу газрын үндсэн зорилго нь байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд халгүй технологид суурилсан өрсөлдөх чадвар бүхий нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, мал

эрүүлжүүлэх замаар аймгийн хүн амын хүнсний баталгаат байдлыг хангах, үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлж буй үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэхэд оршино.

Төв аймгийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /цаашид “газар” гэх/ нь аймгийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хэтийн төлөвийг тодорхойлох, бодлого, төлөвлөлт, хууль тогтоомж, хөтөлбөр төсөл боловсруулж түүний хэрэгжилтийг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг гэж заасны дагуу Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг Цагдаагийн ерөнхий газар баталж Төв аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 4 асуудал эрсдэл өндөр, 2 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-В-4 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 36 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 4 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Хөдөө аж ахуйн яам Төв аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах,

төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 2016 онд 458986.9 мянган төгрөгийн санхүүжилт, 20831.7 мянган төгрөгийн үйл ажиллаганы орлого, нэмэлт санхүүжилтийн дансаар 977076.1 мянган төгрөгийн орлого оржээ. Үүнээс урсгал зардалд 1429208.3 мянган төгрөг, 6,295.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл:

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2016 оны 10 сард хийгдсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгах нийцлийн аудитаар мэдээлбэл зохих мэдээлэлээс 3 мэдээлэл оруулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 5, нарийвчилсан 1, нийт 6 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагавар Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 97.4 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 3578.2 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Гэрээ байгуулалгүй цахилгаан хэрэглэж 2036.1 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлж тайлант оны зардлаар тайлагнасан нь НББ-ийн тухай 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Тайлант оны зардлыг зөв тооцож тайланд тусгаж байх албан шаардлага бичив

2. Царцаа устгах болон огтоно устгалын төсөл хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, баримтын бүрдэл дутуу, анхан шатны баримтгүй 1542.12 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл. “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж, түүнд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага бичив

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

3950.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг олгохдоо урьдчилгаа дансанд бичилт хийлгүй өглөг дансанд бичилт хийсэн НББ-ийн тухай хуулийн 4.1А”ж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3.Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Урьдчилгаа төлбөр, тооцоог бүртгэхдээ авлага, урьдчилгаа дансанд бичилт хийж байх зөвлөмж өгөв.

3. Цахилгаан болон дулааны зардлын бичилтийг нэхэмжилсэн тухай бүр биш бөөн дүнгээр нэг удаа бичилт хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн иөсөвт зохицуулалт хийх журам”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Анхан шатны баримтын үндэслэн ажил гүйлгээг тухай бүр дансанд бүртгэж байх албан шаардлага бичив.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг 3278.2 мянган төгрөг, материаллаг бус 73095.1 мянган төгрөгийн алдаа залруулагдаагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох бараа материалын дансанд завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 76673.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 23453.32 мянган төгрөгийн албан шаардлага, 3950.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийж 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн хариуг албан бичгээр Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт: Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ж.БЯМБАЦОГТ

Огноо: 2017.02.22